

Монгол улс - Хүн Амын Нөхөн Үржихүйн Эрүүл Мэндийн Судалгаа1998

Үндэсний Статистикийн Хороо - ҮСХ

Үүссэн огноо: June 23, 2014

Вэб хуудас: <http://web.nso.mn/nadamn/index.php>

Тойм

Тодорхойлолт

ДУГААР

MNG-NSO-MN-RHS-1998-v3.0

Хувилбар

ХУВИЛБАРЫН ТАЙЛБАР

-v2.0:засварлагдсан мэдээллийн бааз

ҮҮССЭН ОГНОО

1999-08-01

Тойм

ТОВЧ

Судалгааны зорилго нь төрөлтийн түвшин, нялхсын эндэгдэл, гэр бүл төлөвлөлт, төрөхийн өмнөх эмнэлгийн хяналт, жирэмсэн үеийн болон төрөх үеийн хүндрэлтэй холбоотой эхийн эрүүл мэндийн тухай иж бүрэн статистикийн мэдээллийг бий болгоход чиглэсэн. Түүнчлэн энэ судалгаагаар хүүхдийн эрүүл мэнд, хүүхдийг хөхөөр хооллох, гэр бүл төлөвлөлт, ДОХ-ын талаар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн баримталж буй байр суурийн талаарх мэдээллийг цуглуулсан болно. Эдгээр мэдээлэл нь юуны өмнө төрөлт, нялхсын эндэгдлийн түвшинг үнэлэн дүгнэх, эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндэд болон нялхас, хүүхдийн эрүүл мэндэд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг тодруулахад чухал ач холбогдолтой. ХАНҮЭМС-ны үр дүн Монгол улсын эрүүл мэндийн салбарын өөрчлөлтөд чухал хэрэгцээтэй мэдээллийн эх үүсвэр болох юм.

Судалгааны өөр нэг зорилго нь үндэсний хэмжээний томоохон, олон улсын түвшинд харьцуулагдахуйц түүвэр судалгааг явуулах ҮСГ-ын чадавхыг сайжруулахад оршиж байсан. Судалгааны үр дүн нь бодлого боловсруулагчид, эрүүл мэндийн болон эрдэм шинжилгээний ажилтнуудыг бодлого боловсруулах, хөтөлбөрийн гүйцэтгэлийг үнэлэн дүгнэх мөн түүнчлэн эрдэм шинжилгээний ажилд шаардлагатай тоо мэдээллээр хангана гэдэгт итгэж байна.

ХАНҮЭМС-ны зорилт нь:

1. Төрөлт, нас баралт, гэр бүл төлөвлөлттэй холбогдолтой мэдээллийг улсын хэмжээнд цуглуулах;
2. Төрөлтийн түвшин, ЖСАХ-ийн талаарх мэдлэг, хэрэглээг бүс нутаг, байршил, нас, боловсролын түвшин болон бусад сонгосон үзүүлэлтүүдээр тодорхойлох;
3. Хүүхдийн эрүүл мэнд, хөхөөр хооллолтын байдал, жирэмсэн эхчүүдийн төрөхийн өмнөх эмнэлгийн хяналтад хамрагдсан байдал, төрөх үеийн хүндрэл, үр хөндөлт зэрэг эрүүл мэндтэй холбоотой тодорхой асуудлуудаар мэдээлэл цуглуулах;
4. Монгол улсын хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдээллийг өөрийн орон болон дэлхийн улс орнууд, олон улсын байгууллагад түгээх;
5. Бодлого боловсруулагч, судалгаа, шинжилгээний байгууллага, ажилтнуудыг хэрэгцээтэй мэдээллээр хангахад тус тус оршино.

МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ

Sample survey data [ssd]

СУДАЛГААНЫ НЭГЖ

-Өрх

-Нөхөн үржихүйн насны (15-49 насны) эмэгтэйчүүд

-Нөхөр

-Хүүхэд

Хүрээ

ТЭМДЭГЛЭЛҮҮД

1998 оны нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа нь төрөлтийн түвшин, нялхсын эндэгдэл, гэр бүл төлөвлөлт, төрөхийн өмнөх эмнэлгийн хяналт, жирэмсэн үеийн болон төрөх үеийн хүндрэлтэй холбоотой эхийн эрүүл мэндийн тухай иж бүрэн статистикийн мэдээллийг бий болгоход чиглэгдсэн. Түүнчлэн энэ судалгаа нь хүүхдийн эрүүл мэнд, хүүхдийг хөхөөр хооллох, гэр бүл төлөвлөлт, ДОХ-ын талаар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн баримталж буй байр суурийн талаарх мэдээллийг хамарсан болно .

TOPICS

Агуулга	Үгийн сан	URI
health policy [8.6]	CESSDA	http://www.nesstar.org/rdf/common
children [12.1]	CESSDA	http://www.nesstar.org/rdf/common
family life and marriage [12.5]	CESSDA	http://www.nesstar.org/rdf/common
gender and gender roles [12.6]	CESSDA	http://www.nesstar.org/rdf/common
fertility [14.2]	CESSDA	http://www.nesstar.org/rdf/common
social welfare policy [15.1]	CESSDA	http://www.nesstar.org/rdf/common

Ажиглалтын хүрээ

ГАЗАР ЗҮЙН ХҮРЭЭ

Монгол Улсын хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн 1998 оны судалгаа нь Монгол улсыг бүхэлд нь хамарсан үндэсний хэмжээний болон бүсийн (5 бүс - Баруун, Төв, Зүүн, Өмнөд, Улаанбаатар) төлөөлөлтэй түүвэр судалгаа юм.

ХҮРЭЭ

Өрхөд байгаа 15-49 насны бүх эмэгтэйчүүдээс гадна тухайн өрхөд судалгаа явахын өмнөх шөнө хоносон 15-49 насны эмэгтэйчүүдээс эмэгтэйчүүдийн асуулгын хуудсаар, Түүврийн анхан шатны нэгж тус бүрээс ярилцлага өгсөн нийт эмэгтэйчүүдээс зургаан эмэгтэйн нөхрөөс нь нөхрийн асуулгын хуудасны дагуу ярилцлага авсан.

Гүйцэтгэгч болон түнш

АНХНЫ ШИНЖЭЭЧ

Нэр	Харьяалал
Үндэсний Статистикийн Хороо	Улсын Их Хурал

БУСАД ГҮЙЦЭТГЭГЧ

Нэр	Харьяалал	Үүрэг
НҮБ-ын Статистикийн хэлтэс		Техникийн болон санхүүгийн зөвлөгч
Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам		Захиалагч, мэдээллийн хэрэглэгч

САНХҮҮЖИЛТ

Нэр	Товчлол	Үүрэг
НҮБ-ын Хүн амын сан	НҮБХАС	Санхүүжүүлэгч

OTHER ACKNOWLEDGEMENTS

Нэр	Харьяалал	Үүрэг
Ноён. Iqbal Alam	НҮБ-ын Статистикийн хэлтэс	Төслийг батлуулан хэрэгжүүлэгч

Нэр	Харьяалал	Үүрэг
Ноён. Albert M.Marckwardt	НҮБ-ын Статистикийн хэлтэс	Төслийн техникийн суурин зөвлөх
Хатагтай. Linda Demers	НҮБ-ын Статистикийн хэлтэс	Тайлан уншиж зассан зөвлөх
Ноён. А.Амарбал (Ph.D)	НҮБХАС	Төслийн зохицуулагч

Мета мэдээлэл боловсруулалт

БОЛОВСРУУЛСАН

Нэр	Товчлол	Харьяалал	Үүрэг
Зундуйн Нансалмаа		ҮСХ	Баримтжуулалт хийсэн
Цэрэндэжид Цолмон		ҮСХ	Баримтжуулалт хийсэн

МЕТА МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛСАН ОГНОО

2008-02-25

DDI БИЧИГ БАРИМТЫН ХУВИЛБАР

Хувилбар 3.0

DDI БИЧИГ БАРИМТЫН ДУГААР

DDI-MNG-NSO-MN-RHS-1998-v3.0

Түүвэрлэлт

Түүвэрлэлт

Судалгааг аль ч өрх сонгогдож болох тэнцүү магадлал бүхий 2 үе шаттай түүврийн аргыг ашиглан явуулсан. Жил болгон улс орон даяар баг, хороо бүр дээр шинэчлэгдэн хөтлөгдөж байдаг өрхүүдийн жагсаалтыг түүвэрлэлтийн хүрээ болгон авсан юм. Ийм төрлийн судалгааг урд өмнө нь хийж байгаагүй улс оронд анхан шатны түүвэрлэлтийн нэгжээс 25 өрхийг сонгон авахад төлөөлөх чадвар нь сайн болох нь ижил төрлийн судалгаа хийсэн бусад орны туршлагаар нотлогдсон юм. Эл байдлыг үндэслэн уг судалгаанд нэг түүвэр нэгжээс 25 өрх түүвэрлэн авсан. (Хамгийн төлөөлөл сайтай түүвэрлэлтийн нэгжийн "сонголт" нь түүвэрлэлтийн нэгжүүд хоорондын болон түүвэрлэлтийн нэгж доторхи гол гол үзүүлэлтүүдийн ялгаатай байдлаас шалтгаална. Гэхдээ үүнийг зөвхөн судалгаа явуулсны дараа тодорхойлно.) Судалгаанд нийт өрхийн 1,13 хувь буюу 6000 өрхийг хамруулахаар төлөвлөсөн учраас бидэнд нийт 240 анхан шатны нэгжийг түүвэрлэх шаардлага гарч, баг, хороог түүвэрлэлтийн анхан шатны нэгж (ТАШН) болгон авсан. Нийт 1681 ТАШН-үүдийг аймаг болон сумдаар нь эхнээс нь дугаарлан жагсаасан. Түүвэрлэлтийн анхан шатны 240 нэгжийг сонгохдоо эхний ТАШН-ийг санамсаргүй байдлаар сонгон өрхийн тоотой шууд пропорционалаар дараа дараагийн ТАШН-үүдийг сонгосон.

Нэг ТАШН-ийн хүрээнд өрхүүдийг сонгохдоо түүвэрлэлтийн эхний өрхийг санамсаргүй байдлаар эхлээд сонгон авч, дараа нь тухайн ТАШН дэхь өрхийн нийт тоотой шууд пропорционалаар дараагийн сонгогдох өрхийг товлосон. Сонгогдсон өрхүүдээс өрхийн асуулгын хуудасны дагуу ярилцлага авсан. Өрхөд байгаа 15-49 насны бүх эмэгтэйчүүдээс гадна тухайн өрхөд судалгаа явахын өмнөх шөнө хоносон 15-49 насны эмэгтэйчүүдээс эмэгтэйчүүдийн асуулгын хуудсаар, ТАШН тус бүрээс ярилцлага өгсөн нийт эмэгтэйчүүдээс зургаан эмэгтэйн нөхрөөс нь нөхрийн асуулгын хуудасны дагуу ярилцлага авсан. Түүвэрлэлтийг хүснэгт 1.02-д харуулав.

Хүснэгт 1.02 Түүвэрлэгдсэн баг, хороо болон өрхийн тоо, Монгол улс, 1998 он.

Түүвэрлэгдсэн Түүвэрлэгдсэн
Нэгжийн өрхийн тоо
дугаар

- 1 Архангай 1-12 300
- 2 Баян-Өлгий 13-20 200
- 3 Баянхонгор 21-30 250
- 4 Булган 31-37 175
- 5 Говь-Алтай 38-44 175
- 6 Дорноговь 45-49 125
- 7 Дорнод 50-57 200
- 8 Дундговь 58-63 150
- 9 Завхан 64-73 250
- 10 Сэлэнгэ 74-83 250
- 11 Сүхбаатар 84-89 150
- 12 Увс 90-99 249
- 13 Төв 100-110 275
- 14 Өвөрхангай 111-124 350
- 15 Өмнөговь 125-129 125
- 16 Ховд 130-137 200
- 17 Хөвсгөл 138-150 325
- 18 Хэнтий 151-158 200
- 19 Дархан-Уул 159-168 250
- 20 Орхон 169-174 149
- 21 Говьсүмбэр 174-176 50
- 22 Улаанбаатар хот 177-240 1607

Бүгд дүн 6005

Хамралтын түвшин

Судалгааны хамрагдалтын байдал, байршлаар, Монгол улс, 1998 он

Байршил

Хот Хөдөө Бүгд

Сонгогдсон өрх 2931 3074 6005

Ярилцлага авсан өрхийн тоо 2930 3073 6003

Хамруулалтын хувь 100 100 100

Сонгогдсон эмэгтэйчүүд 3943 3610 7553

Ярилцлага авсан эмэгтэйчүүд 3904 3557 7461

Хамруулалтын хувь 99.0 98.5 98.8

Сонгогдсон нөхөр 794 766 1560

Ярилцлага авсан нөхрүүд 793 764 1557

Хамруулалтын хувь 99.9 99.7 99.8

Түүврийн жин

Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн 1998 оны судалгаа нь үндэсний хэмжээний төлөөлөлтэй түүвэр судалгаа юм.

Асуулгууд

Тойм

ХАНҮЭМС-нд гурван төрлийн асуулгын хуудас хэрэглэсэн. Судалгааны эмэгтэйчүүдийн асуулгын хуудсыг боловсруулахад Хүн ам зүй, Эрүүл Мэндийн Судалгааны хөтөлбөр дэхь “В” загварыг суурь болгон авч, Монгол орны онцлог байдлыг тусгаж нэлээд өөрчлөлтүүдийг хийсэн.

Гурван төрлийн асуулгын хуудасны гол гол үзүүлэлтүүдийг жагсаавал:

1. Өрхийн асуулгын хуудас:

- Өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болох;
- Нас;
- Хүйс;
- Боловсролын түвшин;
- Гэрлэлтийн байдал

Өрхийн бүх гишүүд болон судалгаа явахын урд шөнө тухайн өрхөд хоносон гадны хүмүүсээс өрхийн асуулгын хуудасны дагуу дээрх асуултуудыг асуусан юм. Хүн ам зүйн ерөнхий мэдээлэл, өрхийн орон сууцны нөхцөлийг тодруулах, түүнчлэн ганцаарчилсан асуулгад хамрагдах эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг сонгох зорилгоор өрхийн асуулгын хуудсыг боловсруулсан.

2. Эмэгтэйчүүдийн асуулгын хуудас:

- Ерөнхий асуулга;
- Нөхөн үржихүй;
- Эхийн эрүүл мэнд, жирэмслэлт, хөхөөр хооллуулах, хүүхдийн эрүүл мэнд;
- Жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгслийн талаарх мэдлэг, түүний хэрэглээ;
- Гэрлэлтийн байдал;
- Төрөлтийн төсөөлөл ба үр хөндөлт;
- Ажил эрхлэлт, нөхрийн тухай асуултууд;
- Дархлал олдмол хомсдолын (ДОХ) талаарх мэдлэг.

3. Нөхрийн асуулгын хуудас:

- Ерөнхий асуулга;
- Нөхөн үржихүй;
- Жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгслийн талаарх мэдлэг, түүний хэрэглээ;
- ДОХ-ын талаарх мэдлэг.

External Resources хэсгээс асуулгын хуудсыг харна уу.

Мэдээлэл цуглуулалт

Мэдээлэл цуглуулалтын огноо

Эхлэх	Дуусах	Цикл
1998-10-04	1998-12-31	N/A

Мэдээлэл цуглуулалтын бодлого

Face-to-face [f2f]

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН ТЭМДЭГЛЭГЭЭ

1998 оны 9 сарын 14 нөөс 10-р сарын 01-ний хооронд ярилцлага авагч нарт зориулсан сургалт явуулж, улмаар судалгааны мэдээлэл цуглуулах 10 багийг тус бүр 7 хүний бүрэлдэхүүнтэй томилсноор мэдээлэл цуглуулах ажил эхэлсэн. Баг бүр дөрвөн эмэгтэй, нэг эрэгтэй ярилцлага авагч, нэг хянагч, нэг багийн ахлагчаас бүрдэж байсан. Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг эхлэх үед өвлийн улирал ойртсон байсан тул эхлээд уулархаг бүс нутаг болон баруун болон хангайн бүсэд мэдээлэл цуглуулж, дараа нь говийн ба төвийн бүсэд, эцэст нь Улаанбаатар хотод цуглуулахаар төлөвлөсөн. Мэдээлэл цуглуулах ажил 1998 оны 10-р сарын 4-нд эхэлж, мөн оны 12-р сарын 31-нд дууссан.

Баг бүрт хянагч томилж ажиллуулсан бөгөөд хянагч, багийн ахлагч нар нь тухайн өдрийн цуглуулсан мэдээллийг шалган хүлээн авч, алдаатай, тодорхойгүй зүйлийг илрүүлэн шаардлагатай гэж үзвэл газар дээр нь очиж тодруулж байсан. Мэдээлэл цуглуулах ажлыг ингэж зохион байгуулсан нь үнэн зөв, чанартай мэдээлэл цуглуулах боломжийг бүрдүүлсэн. Мөн мэдээлэл цуглуулалтын ажлын явцыг 7 хоног бүр судалгааны зохион байгуулах төв буюу Үндэсний статистикийн газарт танилцуулж байсан. Багийн ахлагч, хянагч нараас гадна судалгаанд хоёр зохицуулагчийг томилж ажиллуулсан. Мөн түүнчлэн аймаг, хот, сум, дүүрэг, баг, хорооны холбогдох ажилтнууд (давхардсан тоогоор 300 гаруй хүн) бидний ажилд тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ хамтран ажилласан болно.

Мэдээлэл цуглуулалт

Нэр	Товчлол	Харьяалал
Үндэсний статистикийн газар	ҮСГ	

SUPERVISION

Хянагч, багийн ахлагч нар нь:

- тухайн өдрийн цуглуулсан мэдээллийг шалган хүлээн авч, алдаатай, тодорхойгүй зүйлийг илрүүлэн шаардлагатай гэж үзвэл газар дээр нь очиж тодруулах
- асуулга бүрийн үнэн зөв, чанартай бөглөсөн эсэхийг шалгах
- зарим ярилцлага авагчийг асуулгын хуудасны дагуу асуултуудыг зөв асууж байгаа эсэхийг ажиглах
- багийн гишүүдтэй өдөр тутмын үйл ажиллагааны талаар ярилцах, зөвөлгөө өгөх
- өрхийн гишүүдэд асуулгын хуудасны талаар тайлбарлах, гарч болох хүндрэлүүдийг шийдвэрлэх ажлуудыг тухай бүр хийдэг

Мэдээлэл боловсруулалт

Мэдээлэл засалт

Судалгааны мэдээллийг компьютерт оруулах ажил 1998 оны 10 сарын 20 ноос 1999 оны 2-р сарын 1-нийг дуустал үргэлжилсэн. Компьютерийн файлуудыг шалган засварлах ажлыг хоёрдугаар сарын дунд үеэр дуусгасан. Судалгааны мэдээллийг оруулах болон боловсруулах ажилд олон улсын "Макро" институтэд боловсруулагдсан компьютерийн ISSA багц програмыг ашигласан. Үр дүнгийн хүснэгтүүдийг 1999 оны хоёрдугаар сараас эхлэн хоёр сарын турш гарган авсан. Мэдээллийг оруулах, мэдээллийн чанарыг шалгах, үр дүнгийн хүснэгтүүдийг боловсруулах ажлуудыг НҮБ-ын техникийн зөвлөх болон НҮБын Улс орныг дэмжих багийн мэргэжилтнүүдийн хяналтын дор үндэсний боловсон хүчнүүд хийж гүйцэтгэсэн. ХАНҮЭМС-ны үндсэн тайланг Үндэсний Статистикийн газрын мэргэжилтнүүд төслийн зөвлөхтэй хамтран бичсэн болно. "Хүн ам зүй, эрүүл мэндийн судалгааны үндсэн илтгэлийг бичихэд зориулсан удирдамж-III" -д өгөгдсөн зөвлөмжийн дагуу гарах хүснэгтийг боловсруулах төлөвлөгөө хийгдсэн.

Бусад боловсруулалт

ХАНҮЭМС-ны ерөнхий үйл явц

Ажил Эхэлсэн Дууссан

1. Судалгааны бэлтгэлийг хангах 01.12.97 01.09.98
2. Туршилтын судалгаа хийх 15.07.98 15.08.98
3. Мэдээлэл цуглуулах 04.10.98 31.12.98
4. Мэдээлэл оруулах, боловсруулах 20.10.98 31.01.99
5. Үр дүнгийн хүснэгтүүдийг боловсруулах 01.12.98 01.02.99
6. Үр дүнгийн хүснэгтүүдийг авах 01.02.99 15.03.99
7. Тайлан илтгэлийг гаргах 15.03.99 01.08.99

Мэдээллийн үнэлэлт

Түүвэрлэлтийн алдааны үнэлэлт

Сонирхол татсан буюу шаардлагатай гэж үзсэн үзүүлэлтүүдийн түүвэрлэлтийн алдааг тооцож хүснэгт В.02- В.16-д харуулсан болно. Эдгээр тооцоог улсын дүнгээр, хот, хөдөөгөөр, боловс ролын түвшингийн дөрвөн бүлгээр, бүс нутгийн таван ангиллаар, насны гурван бүлгээр тус тус харуулсан болно. Түүвэрлэлтийн алдаа тооцсон үзүүлэлтүүд ийн (хувь, дундаж, коэффициентууд) жагсаалтыг, хамрах хүрээний хамт хүснэгт В. 01 -д харуулсан болно. Үзүүлэлт тус бүрийн хувьд, тухайн статистик үзүүлэлтийн хэмжээ (R), түүний түүвэрлэлтийн алдаа (SE), тохиолдлын тоо буюу тухайн үзүүлэлтийн түүвэрлэлтийн хэмжээ (N), хэрэглэсэн түүвэрлэлтийн аргын нөлөөлөл (ХТАН) (DEFT), харьцангуй стандарт алдаа (SE/R), 95 хувийн магадлалын хязгаар (R-2SE, R+2SE) зэргийг хүснэгт В.02- В.16 -д харуулсан болно.

Магадлалын хязгаарыг дараах байдлаар тайлбарлана. Гэр бүлтэй эмэгтэйчүүдийн ерөндөг хэрэглэж байгаа хувь түүвэрлэлтийн бүрэн хэмжээгээр авч тооцсон ерөнхий дүн 32.2 байгаа бөгөөд үүний түүвэрлэлтийн алдаа нь 0.8 хувь байна. Эдгээрийг ашиглан 95 хувийн магадлалын хязгаарыг тооцохын тулд бүтэн түүвэрлэлтээс тооцсон тухайн үзүүлэлтийн энэхүү хэмжээн дээр стандарт алдааг хоёр дахин нэмж, мөн хасч авах юм. Гэр бүлтэй эмэгтэйчүүдийн ерөндөг хэрэглэж байгаа бодит хувь нь 30.6-33.8 хувийн хооронд орших бөгөөд энэ нь 95 хувийн магадлалтай юм.

Улсын хэмжээгээр тооцсон ихэнх үзүүлэлтүүдийн хувьд (маш бага хувь бүхий үзүүлэлтүүдээс бусад) харьцангуй стандарт алдаа нь бага байдаг. Харьцангуй стандарт алдааны цар хүрээ нь түүвэрлэлт ийн хэмжээ багасах тутам, тухайлбал, хүн амыг бүс нутгаар бүлэглэн тооцсон тохи олдолд өсдөг. Жишээлбэл, ерөндөгийн хувьд улсын хэмжээгээр тооцсон харьцангуй стандарт алдаа (тооцсон үзүүлэлтийн хувиар) 2.5 хувь, хотынх 3.5 хувь, хөдөө нийх 3.4 хувь байна. Бүс нутгийн таван бүлгээр авч үзвэл, ерөндөг гэсэн үзүүлэлтийн харьцангуй стандарт алдаа нь 4.2 -оос 9.0 хувийн хооронд хэлбэлзэж байна.

Коэффициентуудын түүвэрлэлтийн алдааны талаар тусгайлан тэмдэглэх нь зүйтэй юм. Коэффициентүүдийн хуваарь нь эрдсэл-жил, хүртвэр нь тухайн цаг хугацаанд тухайн хүн амд тохиолдож байгаа төрөлт эсвэл нас баралтын тоо юм. Судалгаа явахаас өмнөх гурван жилийн байдлаарх төрөлтийн нийлбэр коэффициентын түүвэрлэлтийн алдаа гуравдугаар бүлэгт, арван жилийн байдлаар тооцсон нас баралтын коэффициентүүдийн түүвэрлэлтийн алдааг долоо дугаар бүлэгт тооцож харуулсан. Эдгээр тооцоонуудыг улсын түвшинд, хот-хөдөөгөөр, бүс нутгаар, эхийн боловсролын түвшингээр тус бүрт нь харуулсан болно (Эдгээр нь насны бүлгийн хувьд хамаагүй юм.). Судалгаа явахаас өмнөх таван жилийн байдлаар тооцсон нялхсын нас баралтын коэффициентын түүвэрлэлтийн алдааг авч үзэхдээ тодорхой хэмжээгээр болгоомжтой хандах шаардлагатай байсныг үндэслэн энэ үзүүлэлт болон үүнтэй холбогдолтой тооцоонуудыг зөвхөн улсын түвшингээр харуулсан болно. Судалгаа явахаас өмнөх гурван жилийн байдлаар тооцсон төрөлтийн нийлбэр коэффициент буюу нэг эмэгтэйд ногдох хүүхдийн дундаж тоо нь 2.9 болон 3.2 хүүхдийн хооронд; судалгаа явахаас өмнөх таван жилийн байдлаар тооцсон нялхсын нас баралтын коэффициент нь 56 болон 74 -ын хооронд орших ба эдгээр нь 95 хувийн магадлалтай гэдгийг судалгааны үр дүн харуулж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Судалгааны дүн болон хүн амын ердийн хөдөлгөөний мэдээгээр гарсан коэффициентүүдийн зөрүү нь түүвэрлэлтийн хэлбэлзэлээс огт шалтгаалаагүй юм.

Түүвэрлэлтийн алдааний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг External resources хэсэгт байрлах 1998 оны Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгааны үр дүнгийн тайлангийн хавсралт В-гээс харж болно.

Мэдээлэл үнэлэлтийн бусад хэлбэр

Тайланд тусгаагүй.

Файлын тайлбар

variable_list

Household

Агуулга	1998 оны Нөхөн Үржихүйн Эрүүл Мэндийн Судалгааны өрхийн асуулгаас бүрдсэн мэдээллийн бааз (Асуулга 20-31)
Тохиолдолууд	6003
Хувьсагч	26
Бүтэц	Төрөл: relational Түлхүүрүүд: HNEGJ(Түүвэрлэгдсэн нэгжийн дугаар), HAIM(Аймаг, нийслэл нэр), HSOM(Сум, дүүргийн нэр), HBAG(Баг, хорооны нэр), HHNO(Өрхийн дугаар), HUR(Байршил)
Хувилбар	Хувилбар 2.0
Гүйцэтгэгч	Монгол Улсын Үндэсний статистикийн газар
Missing Data	

Хувьсагчид

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V1118	HNEGJ	Түүвэрлэгдсэн нэгжийн дугаар	discrete	numeric	
V1119	HAIM	Аймаг, нийслэл нэр	discrete	numeric	
V1120	HSOM	Сум, дүүргийн нэр	discrete	numeric	
V1121	HBAG	Баг, хорооны нэр	discrete	numeric	
V1122	HHNO	Өрхийн дугаар	discrete	numeric	
V1123	HUR	Байршил	discrete	numeric	
V1124	HRESULT	Үр дүнгийн код	discrete	numeric	
V1125	HTOTPER	Жагсаалтанд бичигдсэн бүх хүний тоо	contin	numeric	
V1126	Q20	Сууцны төрөл	discrete	numeric	Танай өрх хүйтний улиралд ямар сууцанд амьдардаг вэ?
V1127	Q21	Халаалтын систем	discrete	numeric	Байрныхаа халаалтын төрлийг хэлнэ үү?
V1128	Q22	Угаалгын өрөө	discrete	numeric	Танай байр угаалгын тусдаа өрөөтэй юу?
V1129	Q23	Бие засах газар	discrete	numeric	Танай байрны бие засах цэг хаана байдаг вэ?
V1130	Q24	Цахилгаан	discrete	numeric	Танай өрх цахилгаан хэрэглэдэг үү?
V1131	Q25	Цахилгааны эх үүсвэрийн төрөл	discrete	numeric	Цахилгаанаа хаанаас авдаг вэ?
V1132	Q26	Цахилгаан тасарсан өдөр	contin	numeric	Өнгөрсөн 7 хоногт танайд хэдэн өдөр цахилгаан тасарсан бэ?
V1133	Q27	Ундны усны эх үүсвэр	discrete	numeric	Өрхийнхөө ундны усны эх үүсвэрийг нэрлэнэ үү?
V1134	Q28	Малтай эсэх	discrete	numeric	Танай өрх малтай юу?
V1135	Q29A	Тэмээ	contin	numeric	Танайх хэдэн тэмээтэй вэ ?
V1136	Q29B	Адуу	contin	numeric	Танайх хэдэн адуутай вэ ?
V1137	Q29C	Үхэр	contin	numeric	Танайх хэдэн үхэртэй вэ ?
V1138	Q29D	Хонь	contin	numeric	Танайх хэдэн хоньтой вэ ?
V1139	Q29E	Ямаа	contin	numeric	Танайх хэдэн ямаатай вэ ?
V1140	Q29F	Бусад	contin	numeric	Танайх өөр төрлийн амьтантай юу?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V1141	Q30	Өрхийн орлого хэрэгцээ хангадаг эсэх	discrete	numeric	Танай өрхийн орлого наад захын хэрэгцээгээ хангадаг уу?
V1142	Q31A	Эмнэлгийн тусламж дууддаг хэрэгслэл	discrete	numeric	Эмнэлгийн түргэн тусламжийг ямар хэрэгслээр дууддаг вэ?
V1143	Q31B	Эмнэлэгийн түргэн тусламж авах хугацаа	discrete	numeric	Эмнэлэгийн түргэн тусламж авах хугацаа?

Household Roster

Агуулга	1998 оны Нөхөн Үржихүйн Эрүүл Мэндийн Судалгаанд хамрагдсан өрхийн бүх гишүүд болон судалгаа авахын урд шөнө тухайн өрхөд хоносон гадны хүмүүсээс өрхийн асуулгын хуудасны дагуу асуусан асуултаас бүрдсэн мэдээллийн бааз.(Асуулга 1-13)
Тохиолдолууд	17535
Хувьсагч	19
Бүтэц	Төрөл: relational Түлхүүрүүд: HNEGJ(Түүвэрлэгдсэн нэгжийн дугаар), HAIM(Аймаг, нийслэл нэр), HSOM(Сум, дүүргийн нэр), HBAG(Баг, хорооны нэр), HHNO(Өрхийн дугаар), HUR(Байршил)
Хувилбар	Хувилбар 2.0
Гүйцэтгэгч	Монгол Улсын Үндэсний статистикийн газар
Missing Data	

Хувьсагчид

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V1144	HNEGJ	Түүвэрлэгдсэн нэгжийн дугаар	discrete	numeric	
V1145	HAIM	Аймаг, нийслэл нэр	discrete	numeric	
V1146	HSOM	Сум, дүүргийн нэр	discrete	numeric	
V1147	HBAG	Баг, хорооны нэр	discrete	numeric	
V1148	HHNO	Өрхийн дугаар	discrete	numeric	
V1149	HUR	Байршил	discrete	numeric	
V1150	HRESULT	Үр дүн	discrete	numeric	
V1151	LINENO	Мөрийн дугаар	discrete	numeric	
V1152	RELATIOO	Өрхийн тэргүүлэгчийн хамаарал	discrete	numeric	Өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай вэ?
V1153	USUALLY	Байнга амьдардаг эсэх	discrete	numeric	Энд байнга амьдардаг эсэх?
V1154	HLNIGHT	Урд шөнө гэртээ хоносон эсэх	discrete	numeric	Урьд шөнө гэртээ (энд) хоносон эсэх?
V1155	SEX	Хүйс	discrete	numeric	(Нэр) эрэгтэй юу?, эмэгтэй юу?
V1156	HBYEAR	Төрсөн он	contin	numeric	(Нэр) хэдэн онд төрсөн бэ?
V1157	AGE	Нас	contin	numeric	(Нэр) хэдэн настай вэ?
V1158	SCHOOLAT	Сургуульд сурсан эсэх	discrete	numeric	Та сургуульд сурч байсан уу?
V1159	EDLEVEL	Боловсролын түвшин	discrete	numeric	Эзэмшсэн боловсролын дээд түвшин?
V1160	INSCHOOL	Үргэлжлүүлэх суралцах эсэх	discrete	numeric	Одоо сургуульд сурч байгаа юу?
V1161	MARRSTAT	Гэрлэлтийн байдал	discrete	numeric	Гэрлэлтийн байдал?
V1162	ELIGIBLY	15-49 настай эмэгтэйн мөрийн дугаар	discrete	numeric	

Women

Агуулга	1998 оны Нөхөн Үржихүйн Эрүүл Мэндийн Судалгааны эмэгтэйчүүдийн асуулгаар бүрдүүлсэн мэдээллийн бааз (Асуулга100-808)
Тохиолдолууд	7535
Хувьсагч	152
Бүтэц	Төрөл: relational Түлхүүрүүд: WNEGJ(Түүвэрлэгдсэн нэгжийн дугаар), WAIM(Аймаг, нийслэл нэр), WSOM(Сум, дүүргийн нэр), WBAG(Баг, хорооны нэр), WHHNO(Өрхийн дугаар), WUR(Байршил)
Хувилбар	Хувилбар 2.0
Гүйцэтгэгч	Монгол Улсын Үндэсний статистикийн газар
Missing Data	

Хувьсагчид

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V1163	WNEGJ	Түүвэрлэгдсэн нэгжийн	discrete	numeric	
V1164	WAIM	Аймаг, нийслэл нэр	discrete	numeric	
V1165	WSOM	Сум, дүүргийн нэр	discrete	numeric	
V1166	WBAG	Баг, хорооны нэр	discrete	numeric	
V1167	WHHNO	Өрхийн дугаар	discrete	numeric	
V1168	WUR	Байршил	discrete	numeric	
V1169	RESPNO	Эмэгтэйн мөрийн дугаар	discrete	numeric	
V1170	HUSQUEST	Нөхрөөс нь ярилцлага авсан эсэх	discrete	numeric	Нөхрөөс нь ярилцлага авсан уу?
V1171	WMONTH	Ярилцлага авсан сар	contin	numeric	
V1172	WDAY	Ярилцлага авсан өдөр	contin	numeric	
V1173	WRESULT	Үр дүн	discrete	numeric	
V1174	WVISIT	Очсон удаа	contin	numeric	
V1175	WINTERW	Ярилцлага авагчийн код	discrete	numeric	
V1176	WSUPERV	Багийн ахлагчийн код	discrete	numeric	
V1177	WFEDITOR	Засварласан	discrete	numeric	
V1178	WKEYOPER	Шивсэн	discrete	numeric	
V1179	Q100	Асуулга эхэлсэн цаг	contin	numeric	
V1180	Q100A	Асуулга эхэлсэн минут	contin	numeric	
V1181	Q101	Төрсөн он	contin	numeric	Та хэдэн онд төрсөн бэ ?
V1182	Q101A	Төрсөн сар	discrete	numeric	Та хэдэн сард төрсөн бэ ?
V1183	Q102	Нас	contin	numeric	Та хэдэн настай вэ ?
V1184	Q103	Энэ газар амьдарсан жил	discrete	numeric	Та энэ газар хэдэн жил сууж байгаа вэ?
V1185	Q104	Өмнө амьдарч байсан газар	discrete	numeric	Та өмнө нь хаана амьдарч байсан бэ ?
V1186	Q105	Сургуульд сурч байсан эсэх	discrete	numeric	Та сургуульд сурч байсан уу ?
V1187	Q106	Боловсролын түвшин	discrete	numeric	Та боловсролынхоо дээд түвшинг хэлнэ үү?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V1188	Q107	Уншиж бичих	discrete	numeric	Та ямар нэгэн богино зүйлийг уншаад ойлгодог уу? (сонин, сэтгүүл, захиа)
V1189	Q109	Одоо сурч байгаа эсэх	discrete	numeric	Та одоо сургуульд сурч байгаа юу?
V1190	Q110	Суралцахаа больсон шалтгаан	discrete	numeric	Суралцахаа больсон шалтгаанаа нэрлэнэ үү?
V1191	Q111A	Долоо хоногт ядаж нэг удаа сонин уншдаг эсэх	discrete	numeric	Та долоо хоногт ядаж нэг удаа сонин уншдаг уу?
V1192	Q111B	Долоо хоногт ядаж нэг удаа радио сонсдог эсэх	discrete	numeric	Та долоо хоногт ядаж нэг удаа радио сонсдог уу?
V1193	Q111C	Долоо хоногт ядаж нэг удаа телевизор үздэг эсэх	discrete	numeric	Та долоо хоногт ядаж нэг удаа телевизор үздэг үү?
V1194	Q112	Шашин шүтлэг	discrete	numeric	Та ямар нэг шашныг шүтдэг үү? Хэрэв шүтдэг бол аль шашныг шүтдэг вэ?
V1195	Q200	Төрсөн эсэх	discrete	numeric	Та хүүхэд төрүүлсэн үү ?
V1196	Q201	Хамт амьдардаг хүүхэд	discrete	numeric	Төрүүлсэн хүүхдүүдээс чинь тантай одоо хамт амьдарч байна уу ?
V1197	Q202A	Хамт амьдардаг хүү	contin	numeric	Хамт амьдардаг хүүхдүүдээс чинь хэд нь хүү вэ?
V1198	Q202B	Хамт амьдардаг охин	contin	numeric	Хамт амьдардаг хүүхдүүдээс чинь хэд нь охин бэ?
V1199	Q203	Тусдаа амьдардаг хүүхэд	discrete	numeric	Төрүүлсэн хүүхдүүдээс чинь тантай хамт амьдардаггүй хүүхэд бий юу ?
V1200	Q204A	Тусдаа амьдардаг хүү	contin	numeric	Хамт амьдардаггүй бол хэд нь хүү вэ?
V1201	Q204B	Тусдаа амьдардаг охин	contin	numeric	Хамт амьдардаггүй бол хэд нь охин бэ?
V1202	Q205	Амьд төрөөд эндсэн хүүхэд	discrete	numeric	Амьд төрөөд эндсэн хүүхэд бий юу ?
V1203	Q206A	Эндсэн хүү	contin	numeric	Хэдэн хүү эндсэн бэ ?
V1204	Q206B	Эндсэн охин	contin	numeric	Хэдэн охин эндсэн бэ ?
V1205	Q207	Нийт төрүүлсэн хүүхдийн тоо	contin	numeric	
V1206	Q220	1990 оны 1 сараас хойш төрсөн хүүхдийн тоо	contin	numeric	
V1207	Q221	Одоо жирэмсэн эсэх	discrete	numeric	Та одоо жирэмсэн үү ?
V1208	Q222	Жирэмсэний сар	contin	numeric	Жирэмслээд хэдэн сар болж байна вэ ?
V1209	Q223	Жирэмсэн болохыг хүсэж байсан эсэх	discrete	numeric	Энэ жирэмслэлтийн талаарх таны санал бодол ямар вэ?
V1210	Q224	Анхны сарын тэмдэг	contin	numeric	Хэдэн настай байхад сарын тэмдэг анх ирсэн бэ?
V1211	Q225	Сарын тэмдэгийн талаарх мэдлэг	discrete	numeric	Сарын тэмдгийн талаар анх хэнээс мэдсэн бэ ? (Сарын тэмдэг ирэхээс өмнө)
V1212	Q226	Сарын тэмдгүүдийн хооронд жирэмслэх боломжтой өдрүүд	discrete	numeric	Сарын тэмдгүүдийн хооронд жирэмслэх боломжтой өдрүүд байдаг гэдгийг та мэдэх үү?
V1213	Q227	Жирэмслэх боломж ихтэй байдаг өдрүүд	discrete	numeric	Сарын тэмдгийн хоорондох аль үед нь жирэмслэх боломж ихтэй байдаг гэж та боддог вэ?
V1214	Q228A	Сүүлийн сарын тэмдэг ирсэн өдөр	discrete	numeric	Сүүлийн сарын тэмдэг хэдийд ирсэн бэ?
V1215	Q228B	Сүүлийн сарын тэмдгийн шалтгаан	discrete	numeric	Сүүлийн сарын тэмдэг хэдийд ирсэн бэ?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V1216	WSECT06_GROUP\$01	Жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга, ЭМ	discrete	character	401.Жирэмснээс урьдчилан сэргийлэх ямар нэг арга хэрэгслийн талаар та сонсож байсан уу? 1-ЭМ (Эмэгтэй нь өдөр бүр эм ууж сэргийлэх) 402.Та . . . аргын талаар сонсож байсан уу? 1-Сонсож байсан 2-Тийм 3-Үгүй 403.Та . . . аргыг хэрэглэж байсан уу? 1-Тийм 2-Үгүй
V1217	WSECT06_GROUP\$02	Жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга, ЕРӨНДӨГ	discrete	character	401.Жирэмснээс урьдчилан сэргийлэх ямар нэг арга хэрэгслийн талаар та сонсож байсан уу? 2- ЕРӨНДӨГ (Эмч, эх баригчийн тусламжтайгаар савны амсарт байрлуулдаг ороомог) 402.Та . . . аргын талаар сонсож байсан уу? 1-Сонсож байсан 2-Тийм 3-Үгүй 403.Та . . . аргыг хэрэглэж байсан уу? 1-Тийм 2-Үгүй
V1218	WSECT06_GROUP\$03	Жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга, ТАРИА	discrete	character	401.Жирэмснээс урьдчилан сэргийлэх ямар нэг арга хэрэгслийн талаар та сонсож байсан уу? 3-ТАРИА (Эмч, сувилагчаар тариулж 1 сараас 3, 1-6 сараар жирэмслүүлэхгүй байх тариа) 402.Та . . . аргын талаар сонсож байсан уу? 1-Сонсож байсан 2-Тийм 3-Үгүй 403.Та . . . аргыг хэрэглэж байсан уу? 1-Тийм 2-Үгүй
V1219	WSECT06_GROUP\$04	Жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга, СУУЛГАЦ	discrete	character	401.Жирэмснээс урьдчилан сэргийлэх ямар нэг арга хэрэгслийн талаар та сонсож байсан уу? 4-СУУЛГАЦ (Эмэгтэй нь гарын шууны арьсан дор 6 ширхэг суулгацыг тавих) 402.Та . . . аргын талаар сонсож байсан уу? 1-Сонсож байсан 2-Тийм 3-Үгүй 403.Та . . . аргыг хэрэглэж байсан уу? 1-Тийм 2-Үгүй
V1220	WSECT06_GROUP\$05	Жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга, ДИАФРАГМ/ЛАА/ЦАРЦМАГ	discrete	character	401.Жирэмснээс урьдчилан сэргийлэх ямар нэг арга хэрэгслийн талаар та сонсож байсан уу? 5-ДИАФРАГМ/ЛАА/ЦАРЦМАГ (Хурьцлын өмнө эмэгтэйчүүд үтрээндээ хийдэг 3 зориулалтын тос /лаа/ царцмаг) 402.Та . . . аргын талаар сонсож байсан уу? 1-Сонсож байсан 2-Тийм 3-Үгүй 403.Та . . . аргыг хэрэглэж байсан уу? 1-Тийм 2-Үгүй
V1221	WSECT06_GROUP\$06	Жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга, БЭЛГЭВЧ	discrete	character	401.Жирэмснээс урьдчилан сэргийлэх ямар нэг арга хэрэгслийн талаар та сонсож байсан уу? 6-БЭЛГЭВЧ (Хурьцлын үед эрэгтэй нь резинэн углааш хэрэглэдэг) 402.Та . . . аргын талаар сонсож байсан уу? 1-Сонсож байсан 2-Тийм 3-Үгүй 403.Та . . . аргыг хэрэглэж байсан уу? 1-Тийм 2-Үгүй
V1222	WSECT06_GROUP\$07	Жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга, ЭМЭГТЭЙН ҮРИЙН СУВГИЙГ БООХ	discrete	character	401.Жирэмснээс урьдчилан сэргийлэх ямар нэг арга хэрэгслийн талаар та сонсож байсан уу? 7-ЭМЭГТЭЙН ҮРИЙН СУВГИЙГ БООХ (Эмэгтэйчүүдэд дахин хүүхэд гаргуулахгүйн тулд үрийн сувгийг боох мэс засал хийдэг) 402.Та . . . аргын талаар сонсож байсан уу? 1-Сонсож байсан 2-Тийм 3-Үгүй 403.Та . . . аргыг хэрэглэж байсан уу? 1-Тийм 2-Үгүй

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V1223	WSECT06_GROUP\$08	Жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга, ЭРЭГТЭЙН ҮРИЙН СУВГИЙГ БООХ	discrete	character	401.Жирэмснээс урьдчилан сэргийлэх ямар нэг арга хэрэгслийн талаар та сонсож байсан уу? 8-ЭРЭГТЭЙН ҮРИЙН СУВГИЙГ БООХ (Эрэгтэйн үрийн сувгийг 2 талд нь тасалж боох мэс засал хийнэ) 402.Та аргын талаар сонсож байсан уу? 1-Сонсож байсан 2-Тийм 3-Үгүй 403.Та аргыг хэрэглэж байсан уу? 1-Тийм 2-Үгүй
V1224	WSECT06_GROUP\$09	Жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга, ХУАНЛИ	discrete	character	401.Жирэмснээс урьдчилан сэргийлэх ямар нэг арга хэрэгслийн талаар та сонсож байсан уу? 9-ХУАНЛИ (Эмэгтэйн жирэмсэн болох боломж ихтэй хоногуудад хосууд хурьцал хийхээ зогсоодог) 402.Та аргын талаар сонсож байсан уу? 1-Сонсож байсан 2-Тийм 3-Үгүй 403.Та аргыг хэрэглэж байсан уу? 1-Тийм 2-Үгүй
V1225	WSECT06_GROUP\$10	Жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга, ГАДУУР ТАВИХ	discrete	character	401.Жирэмснээс урьдчилан сэргийлэх ямар нэг арга хэрэгслийн талаар та сонсож байсан уу? 10-ГАДУУР ТАВИХ (Эрэгтэй нь хурьцлын үед анхааралтай байж үрийн шингэнээ гадуур гаргах) 402.Та аргын талаар сонсож байсан уу? 1-Сонсож байсан 2-Тийм 3-Үгүй 403.Та аргыг хэрэглэж байсан уу? 1-Тийм 2-Үгүй
V1226	WSECT06_GROUP\$11	Жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга, БУСАД	discrete	character	401.Жирэмснээс урьдчилан сэргийлэх ямар нэг арга хэрэгслийн талаар та сонсож байсан уу? 11-Жирэмслэлтээ хойшлуулахын тулд хэрэглэдэг өөр аргын талаар та сонссон уу? 402.Та аргын талаар сонсож байсан уу? 1-Сонсож байсан 2-Тийм 3-Үгүй 403.Та аргыг хэрэглэж байсан уу? 1-Тийм 2-Үгүй
V1227	WSECT06_GROUP\$12	Жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга, хэрэгсэл	discrete	character	401.Жирэмснээс урьдчилан сэргийлэх ямар нэг арга хэрэгслийн талаар та сонсож байсан уу? 12-Жирэмслэлтээ хойшлуулахын тулд хэрэглэдэг өөр аргын талаар та сонссон уу? 402.Та аргын талаар сонсож байсан уу? 1-Сонсож байсан 2-Тийм 3-Үгүй 403.Та аргыг хэрэглэж байсан уу? 1-Тийм 2-Үгүй
V1228	Q405	Жирэмслүүлэхгүй байх ямар нэг арга, хэрэгсэл	discrete	numeric	Та ер нь жирэмслэхгүй буюу жирэмслэлтээ хойшлуулахын тулд ямар нэг арга, хэрэгсэл хэрэглэж байсан уу?
V1229	Q406	Жирэмслэлтээс сэргийлэхийн тулд анх хэрэглэж байсан арга	discrete	numeric	Жирэмслэлтээс сэргийлэх/зайлсхийхийн тулд анх хэрэглэж байсан арга, хэрэгсэл чинь юу вэ?
V1230	Q407	Анхны аргыг хэрэглэж байх үедээ хэдэн хүүхэдтэй байсан	contin	numeric	Та анхныхаа энэ аргыг хэрэглэж байх үедээ хэдэн хүүхэдтэй байсан бэ?
V1231	Q408	Анхны аргыг хэрэглэж байх үедээ хэдэн настай байсан	contin	numeric	Та анхныхаа энэ аргыг хэрэглэж байх үедээ хэдэн настай байсан бэ?
V1232	Q409B	Одоо ямар нэгэн арга хэрэглэж байгаа эсэх	discrete	numeric	Та одоо ямар нэг арга хэрэглэж байна уу?
V1233	Q410	Одоо хэрэглэж байгаа арга	discrete	numeric	Одоо ямар аргыг нь хэрэглэж байна вэ?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V1234	Q411	Одоо хэрэглэж байгаа арга Хугацаа	contin	numeric	Та энэ аргыг хэр удаан хугацаагаар үргэлжлүүлэн хэрэглэж байна вэ?
V1235	Q412Y	Мэс засал хийлгэсэн он	contin	numeric	Хэдэн онд мэс засал хийлгэсэн бэ?
V1236	Q412M	Мэс засал хийлгэсэн сар	contin	numeric	Хэдэн сард мэс засал хийлгэсэн бэ?
V1237	Q414	Ямар нэгэн арга хэрэгслийн өртөг	discrete	numeric	Энэ арга, хэрэгслийг хэрэглэхэд ямар нэг үйлчилгээний болон худалдан авах зардал гардаг уу?
V1238	Q414B	Нэг удаад хэдэн төгрөг зарцуулдаг	contin	numeric	Зардал гардаг бол нэг удаад хэдэн төгрөг зарцуулдаг вэ?
V1239	Q415	Арга хэрэгслийн эх үүсвэр	discrete	numeric	Та 413-д хэлсэн арга, хэрэгслийг хаанаас олж авдаг вэ?
V1240	Q416	Одоо хэрэглэж байгаа аргыг ашиглахад гардаг бэрхшээл	discrete	numeric	Таны одоо хэрэглэж байгаа аргыг ашиглахад ямар нэг бэрхшээл гардаг уу?
V1241	Q417	Гол бэрхшээл	discrete	numeric	Тохиолдох гол бэрхшээлээ нэрлэнэ үү?
V1242	Q418	Одоогийн энэ аргыг хэрэглэхээс өмнө нь хэрэглэж байсан арга	discrete	numeric	Та одоогийн энэ аргыг хэрэглэхээс өмнө нь ямар арга хэрэглэж байсан бэ?
V1243	Q419	Арга өөрчилсөн шалтгаан	discrete	numeric	Та яагаад аргаа өөрчилсөн бэ?
V1244	Q420	Ямар нэгэн арга хэрэглэхийг хүсэж байгаа эсэх	discrete	numeric	Та цаашид дээрх аргуудын аль нэгийг хэрэглэхийг хүсч байна уу?
V1245	Q421	Хэрэглэхийг хүсэж байгаа арга	discrete	numeric	Та аль аргыг хэрэглэхийг хүсч байна вэ?
V1246	Q422	Арга, хэрэгслийг хэрэглэхгүй байгаа гол шалтгаан	discrete	numeric	Эдгээр арга, хэрэгслийг хэрэглэхгүй байгаа гол шалтгаан нь юу вэ?
V1247	Q424	Эмэгтэйн үрийн сувгийг боох мэс засал	discrete	numeric	Хүүхэд төрүүлэхгүйн тулд эмэгтэйн үрийн сувгийг боох мэс заслын аргыг та юу гэж үзэж байна вэ? Зөв үү, буруу юу, танд хамаагүй юу?
V1248	Q425	Эмэгтэйн үрийн сувгийг боох мэс заслыг буруу гэж үзэж байгаа шалтгаан	discrete	numeric	Та яагаад буруу гэж үзэж байна вэ?
V1249	Q427	Эрэгтэйн үрийн сувгийг боох мэс засал	discrete	numeric	Эрэгтэйн үрийн сувгийг боох мэс заслын аргыг та юу гэж үзэж байна вэ? Зөв үү, буруу юу, танд хамаагүй гэж бодож байна уу?
V1250	Q428	Эрэгтэйн үрийн сувгийг боох мэс заслыг буруу гэж үзэж байгаа шалтгаан	discrete	numeric	Та яагаад буруу гэж үзэж байна вэ?
V1251	Q500	Гэрлэлтийн байдал	discrete	numeric	Та гэр бүлийн байдлаа хэлнэ үү?
V1252	Q501	Гэрлэлтийн тоо	discrete	numeric	Та хэдэн удаа гэрлэж (хамт амьдарч) байсан бэ?
V1253	Q502Y	Гэрлэсэн он	contin	numeric	Анх хэдэн онд нөхөртэйгээ гэрлэж/хамт амьдарч эхэлсэн бэ?
V1254	Q502M	Гэрлэсэн сар	contin	numeric	Анх хэдэн сард нөхөртэйгээ гэрлэж/хамт амьдарч эхэлсэн бэ?
V1255	Q503	Гэрлэх үеийн нас	contin	numeric	Та анх гэрлэх (хамт амьдрах) үедээ хэдэн настай байсан бэ?
V1256	Q504	Бэлгийн харьцаанд орсон үеийн нас	contin	numeric	Та ер нь бэлгийн харьцаанд орсон уу? Хэрвээ орсон бол анх хэдэн настай байхдаа орсон бэ?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V1257	Q506A	Хамгийн сүүлийн бэлгийн харьцаа: Код	discrete	numeric	Та хамгийн сүүлд хэзээ (хэдэн өдөр, 7 хоног, сар, жилийн өмнө) бэлгийн харьцаанд орсон бэ?
V1258	Q506B	Хамгийн сүүлийн бэлгийн харьцаа:	discrete	numeric	Та хамгийн сүүлд хэзээ бэлгийн харьцаанд орсон бэ?
V1259	Q601	Хүүхэд төрүүлэх хүсэлтэй эсэх	discrete	numeric	Жирэмсэн биш,итгэлгүй:Та хүүхэд (нэмж) төрүүлэх үү, төрүүлэхгүй юу? Жирэмсэн: Та одоогийн хүүхдээ төрүүлээд дахиж хүүхэд төрүүлэх үү,төрүүлэхгүй юу?
V1260	Q602	Хэдэн хүүхэд нэмж төрүүлэх хүсэлтэй	contin	numeric	Та нэмж хэдэн хүүхэд төрүүлэх вэ?
V1261	Q603	Хүүхэд нэмж төрүүлэх шалтгаан	discrete	numeric	Та яагаад хүүхэд нэмж төрүүлэх гэж бодож байна вэ?
V1262	Q604A	Дараачийн хүүхэдтэй болох хугацаа	discrete	numeric	Жирэмсэн биш,итгэлгүй: Дараачийн хүүхэдтэй болтол хэр удаан хүлээе гэж бодож байна вэ? Жирэмсэн:Энэ хүүхдээ төрүүлээд,дараачийн хүүхэдтэй болтол хэр удаан хүлээе гэж бодож байна вэ?
V1263	Q604B	Дараачийн хүүхэдтэй болох эсэх	discrete	numeric	Жирэмсэн биш,итгэлгүй: Дараачийн хүүхэдтэй болтол хэр удаан хүлээе гэж бодож байна вэ? Жирэмсэн:Энэ хүүхдээ төрүүлээд,дараачийн хүүхэдтэй болтол хэр удаан хүлээе гэж бодож байна вэ?
V1264	Q605	Нэмж хүүхэд гаргахгүй байх гол шалтгаан	discrete	numeric	Танд нэмж хүүхэд гаргахгүй байх ямар гол шалтгаан байна вэ?
V1265	Q606	Тохиромжтой хүүхдийн тоо	contin	numeric	Хүүхэдтэй:Хүүхэдгүй байх үедээ эргэж очих боломж танд тохиолдлоо гэхэд та амьдралдаа хэдэн хүүхэдтэй байвал зохимжтой гэж үзэж байна вэ? Хүүхэдгүй:Хэрвээ таны хүссэн тооны хүүхэд төрүүлэх боломж нөхцөл бүрдвэл та хэдэн хүүхэд төрүүлэх байсан бэ?
V1266	Q607	Жирэмснээс сэргийлэх арга хэрэгслэл хэрэглэж байгаа тухай	discrete	numeric	Хосууд жирэмснээс сэргийлэх арга хэрэгслэл хэрэглэж байгааг та юу гэж үздэг вэ?
V1267	Q608A	Гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл:Радио	discrete	numeric	Сүүлийн 1 сард та гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээллийн хэрэгслээр сонсож, үзсэн үү? Радио:
V1268	Q608B	Гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл:TV	discrete	numeric	Сүүлийн 1 сард та гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээллийн хэрэгслээр сонсож, үзсэн үү? Телевизор:
V1269	Q608C	Гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл:Сонин, сэтгүүл, ном:	discrete	numeric	Сүүлийн 1 сард та гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээллийн хэрэгслээр сонсож, үзсэн үү? Сонин, сэтгүүл, ном:
V1270	Q608D	Гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл:Зурагт хуудас:	discrete	numeric	Сүүлийн 1 сард та гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээллийн хэрэгслээр сонсож, үзсэн үү? Зурагт хуудас:
V1271	Q609	Гэр бүл төлөвлөлтийн талаар хэн нэгэнтэй ярилцсан эсэх	discrete	numeric	Сүүлийн сард та гэрийнхэн, найз, нөхөд, хамаатан, садан, хөршүүдтэйгээ гэр бүл төлөвлөлтийн талаар ярилцаж байсан уу?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V1272	Q610	Гэр бүл төлөвлөлтийн талаар хэнтэй ярилцсан	discrete	character	Хэнтэй ярилцаж байсан бэ?
V1273	Q612	Гэр бүл төлөвлөлтийн талаарх нөхрийн хандлага	discrete	numeric	Таны нөхөр/хос бусад хүмүүсийг ЖУСАХ хэрэглэдэгийг юу гэж үздэг вэ?
V1274	Q613A	Хэдэн хүүхэдтэй болох талаар нөхөртэйгээ ярьдаг эсэх	discrete	numeric	Та нөхөртэйгээ (хос) хэдэн хүүхэдтэй болох талаар ярилцаж байсан уу?
V1275	Q613B	Хүүхдийн тооны хувьд таны нөхөр/хос тантай ижил тооны хүүхэд хүсдэг эсэх	discrete	numeric	Таны нөхөр/хос хүүхдийн тооны хувьд тантай ижил тооны хүүхэд хүсдэг үү, аль эсвэл таныхаас их үү, бага уу?
V1276	Q614	Хүсээгүй жирэмслэлт	discrete	numeric	Зарим үед хүсээгүй байхад жирэмсэлдэг тохиолдол байдаг. Өнгөрсөн хугацаанд та хүсээгүйгээр жирэмслэж байсан уу?
V1277	Q615Y	Хүсээгүй жирэмслэсэн он	contin	numeric	Хамгийн сүүлд хэдэн онд та хэзээ хүсээгүйгээр жирэмсэлсэн бэ?
V1278	Q615M	Хүсээгүй жирэмслэсэн сар	contin	numeric	Хамгийн сүүлд хэдэн сард та хэзээ хүсээгүйгээр жирэмсэлсэн бэ?
V1279	Q616	Хүсээгүй жирэмслэлтийн үр дүн	discrete	numeric	Энэ үед та юу хийсэн бэ?
V1280	Q617	Жирэмслэлтээ зогсоохын тулд хэрэглэсэн арга	discrete	numeric	Жирэмслэлтээ зогсоохын тулд ямар арга хэрэглэсэн бэ?
V1281	Q618	Жирэмслэлтээ зогсооход тусалсан хүн	discrete	numeric	Жирэмслэлтээ зогсооход хэн танд тусалсан бэ?
V1282	Q619	Жирэмслэлтээ зогсоосны дараа эмнэлгийн тусламж шаардлагатай болсон эсэх	discrete	numeric	Жирэмслэлтээ зогсоосны (зогсоох оролдлого) улмаас эмнэлгийн байгууллагад хандах зайлшгүй шаардлага гарсан уу?
V1283	Q620	Эмнэлэгт хэвтсэн эсэх	discrete	numeric	Үүний улмаас та эмнэлэгт хэвтсэн үү ?
V1284	Q701	Нөхөр/хамтран амьдрагчийн нас	contin	numeric	Таны нөхөр/хамтран амьдрагч тань хэдэн настай вэ?
V1285	Q702	Нөхөр/хамтран амьдрагчийн сургуульд сурсан эсэх	discrete	numeric	Таны нөхөр/хамтран амьдрагч тань ямар нэг түвшний боловсролтой юу?
V1286	Q703	Нөхөр/хамтран амьдрагчийн боловсрол	discrete	numeric	Боловсролын түвшнийг нь нэрлэнэ үү?
V1287	Q704A	Нөхөр/хамтран амьдрагчийн ажил эрхлэлт	discrete	numeric	Таны нөхөр (хамтран амьдрагч) голдуу ямар ажил эрхэлж байна вэ?
V1288	Q704C	Нөхөр/хамтран амьдрагчийн одоогийн ажил эрхлэлт	discrete	numeric	Таны нөхөр (хамтран амьдрагч) ямар нэг ажил эрхэлж байна уу?
V1289	Q704D	Нөхөр/хамтран амьдрагчийн ажлын сектор	discrete	numeric	Ажил эрхэлдэг бол ямар секторт ажилладаг вэ?
V1290	Q705	Нөхөр/хамтран амьдрагч тамхи татдаг эсэх	discrete	numeric	Таны нөхөр (хамтран амьдрагч) тамхи татдаг уу? Хэрэв татдаг бол өдөрт хичнээн ширхэг тамхи татдаг вэ?
V1291	Q706	Гэрийн ажлаас гадна одоогоор ажил хийж байгаа	discrete	numeric	Өөрийн гэрийн ажлаас гадна та одоогоор ажил хийж байгаа юу?
V1292	Q707	Гэрийн ажлаас гадна одоогоор ямар нэгэн ажил хийж байгаа эсэх	discrete	numeric	Одоогоор та эдгээр ажлаас аль нэгийг нь хийж байна уу, аль эсвэл өөр ажил хийж байна уу?
V1293	Q708	Сүүлийн 12 сард эрхэлсэн ажил	discrete	numeric	Сүүлийн 12 сард та ямар нэг ажил эрхэлж байсан уу?
V1294	Q709A	Ажил эрхлэлт	discrete	numeric	Та голдуу ямар ажил эрхэлж байна вэ?
V1295	Q709B	Эдийн засгийн сектор	discrete	numeric	Та ямар секторт ажиллаж байна вэ ?

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V1296	Q710	Жилийн турш ажилладаг эсэх	discrete	numeric	Та бүтэн жилийн турш ажилладаг уу эсвэл улирлаар уу?эсвэл хааяа нэг үү?
V1297	Q711	Сүүлийн 12 сарын хэдэн сард нь ажил эрхэлсэн	contin	numeric	Та сүүлийн 12 сард хэдэн сард нь ажил хийсэн бэ?
V1298	Q712	7 хоногт ажилласан дундаж өдөр	contin	numeric	Та долоо хоногт дунджаар хэдэн өдөр ажилладаг бэ?
V1299	Q713	Сүүлийн 12 сард ойролцоогоор ажилласан өдөр	contin	numeric	Сүүлийн 12 сард та ойролцоогоор хэдэн өдөр ажилласан бэ?
V1300	Q714	Олсон орлого	discrete	numeric	Ажил хийснийхээ төлөө та цалин, хөлс авсан уу?
V1301	Q715	Орлогын дүн хүрэлцээтэй эсэх	discrete	numeric	Таны авдаг цалин, хөлс, орлого чинь амьдралд тань хүрэлцээтэй юу? үгүй юу?
V1302	Q716	Олсон орлогоо зарцуулах шийвэр гаргагч	discrete	numeric	Гэрлэсэн, хамт амьдардаг:Цалин, орлогоо яаж зарцуулахыг хэн илүү мэддэг вэ? Та юу, таны нөхөр үү,хамт шийддэг үү? Огт гэрлээгүй, бэлэвсэн, салсан: Цалин, орлогоо яаж зарцуулахыг хэн илүү мэддэг вэ?Та юу, таны эцэг, эх үү, бусадтай хамт шийддэг үү ?
V1303	Q717	Тамхи татдаг эсэх	contin	numeric	Та тамхи татдаг уу?
V1304	Q718	Тамхи татаж эхэлсэн нас	contin	numeric	Та хэдэн настайгаасаа эхэлж тамхи татсан бэ?
V1305	Q800	ДОХ-н талаар сонссон эсэх	discrete	numeric	Та ер нь ДОХ-ын талаар сонссон уу?
V1306	Q801	ДОХ-н талаар мэдээлэл авдаг эх сурвалж	discrete	character	Та ДОХ-ын талаар ихэвчлэн ямар эх сурвалжаас мэдээлэл авдаг вэ? Өөр ямар нэг эх сурвалж байна уу?
V1307	Q802	ДОХ-ын нянгаас сэргийлэх боломж	discrete	numeric	Танд ДОХ-ын нянгаас сэргийлэх боломж бий юу?
V1308	Q803	ДОХ-ын нянгаас яаж сэргийлэх	discrete	character	Хэрэв боломжтой бол юу хийх ёстой вэ? Өөр ямар нэг эх сурвалж байна уу?
V1309	Q804	Эрүүл хүн ДОХ-ын нян тээгч байдаг эсэх	discrete	numeric	Эрүүл хүн ДОХ-ын нян тээгч байж болох уу ?
V1310	Q805	ДОХ туссан хүн нас барах эсэх	discrete	numeric	Таны бодлоор ДОХ туссан хүн нас барах уу?
V1311	Q806	ДОХ -ын халдвар авах магадлал	discrete	numeric	Таны хувьд ДОХ -ын халдвар авах магадлал хэр зэрэг байна вэ?
V1312	Q807	ДОХ-н талаар сонссоноор гарсан бэлгийн харьцааны өөрчлөлт	discrete	character	ДОХ-ын талаар сонссоноор таны бэлгийн харьцаанд өөрчлөлт орсон уу?
V1313	Q808A	Асууж дууссан цаг	contin	numeric	
V1314	Q808B	Асууж дууссан минут	contin	numeric	

Husband

Агуулга	1998 оны Нөхөн Үржихүйн Эрүүл Мэндийн Судалгааны эрэгтэйчүүдийн асуулгаар бүрдүүлсэн мэдээллийн бааз(Асуулга 100-408)
Тохиолдолууд	1573
Хувьсагч	76
Бүтэц	Төрөл: relational Түлхүүрүүд: NEGJ(Түүвэрлэгдсэн нэгжийн дугаар), AIM(Аймаг, нийслэл нэр), SOM(Сум, дүүргийн нэр), BAG(Баг, хорооны нэр), HHNUM(Өрхийн дугаар), UR(Байршил), WLINENO(Эхнэрийн мөрийн дугаар)
Хувилбар	Хувилбар 2.0
Гүйцэтгэгч	Монгол Улсын Үндэсний статистикийн газар
Missing Data	

Хувьсагчид

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V1315	NEGJ	Түүвэрлэгдсэн нэгжийн дугаар	discrete	numeric	
V1316	AIM	Аймаг, нийслэл нэр	discrete	numeric	
V1317	SOM	Сум, дүүргийн нэр	discrete	numeric	
V1318	BAG	Баг, хорооны нэр	discrete	numeric	
V1319	HHNUM	Өрхийн дугаар	discrete	numeric	
V1320	UR	Байршил	discrete	numeric	
V1321	RESPNUM	Нөхрийн мөрийн дугаар	discrete	numeric	
V1322	WLINENO	Эхнэрийн мөрийн дугаар	discrete	numeric	
V1323	INTERM	Ярилцлага авсан сар	contin	numeric	
V1324	INTERD	Ярилцлага авсан өдөр	contin	numeric	
V1325	INTERRES	Үр дүн	discrete	numeric	
V1326	VISIT	Очсон удаа	contin	numeric	
V1327	INTERW	Ярилцлага авагчийн код	discrete	numeric	
V1328	SUPERVIS	Багийн ахлагчийн код	discrete	numeric	
V1329	EDITOR	Засварлагч код	discrete	numeric	
V1330	OPERATOR	Шивэгчийн код	contin	numeric	
V1331	H100H	Асуулга эхэлсэн цаг	contin	numeric	
V1332	H100M	Асуулга эхэлсэн минут	contin	numeric	
V1333	H101Y	Төрсөн он	contin	numeric	Та хэдэн онд төрсөн бэ ?
V1334	H101M	Төрсөн сар	contin	numeric	Та хэдэн сард төрсөн бэ ?
V1335	H102	Нас	contin	numeric	Та хэдэн настай вэ ?
V1336	H103	Энд байнга амьдарсан эсэх	discrete	numeric	Та энэ газар хэдэн жил сууж байгаа вэ?
V1337	H104	Өмнө амьдарсан газар	discrete	numeric	Та өмнө нь хаана амьдарч байсан бэ ?
V1338	H105	Сургуульд сурсан эсэх	discrete	numeric	Та сургуульд сурч байсан уу ?
V1339	H106	Боловсролын түвшин	discrete	numeric	Та боловсролынхоо дээд түвшинг хэлнэ үү?
V1340	H107	Уншиж чаддаг эсэх	discrete	numeric	Та ямар нэгэн богино зүйлийг уншаад ойлгодог уу? (сонин, сэтгүүл, захиа)

ID	Нэр	Шошго	Төрөл	Бичлэгийн хэлбэр	Асуулт
V1341	H108A	Долоо хоногт ядаж нэг удаа сонин уншдаг эсэх	discrete	numeric	Та долоо хоногт ядаж нэг удаа сонин уншдаг уу?
V1342	H108B	Долоо хоногт ядаж нэг удаа радио сонсдог эсэх	discrete	numeric	Та долоо хоногт ядаж нэг удаа радио сонсдог уу?
V1343	H108C	Долоо хоногт ядаж нэг удаа телевизор үздэг эсэх	discrete	numeric	Та долоо хоногт ядаж нэг удаа телевизор үздэг үү?
V1344	H109	Шашин шүтлэг	discrete	numeric	Та ямар нэг шашныг шүтдэг үү? Хэрэв шүтдэг бол аль шашныг шүтдэг вэ?
V1345	H110	Ажил эрхлэлт	discrete	numeric	Та голдуу ямар ажил эрхлэж байна вэ?
V1346	H111	Сүүлийн 12 сард ажил эрхэлсэн эсэх	discrete	numeric	Та сүүлийн 12 сард ямар нэгэн ажил эрхэлсэн үү ?
V1347	H112	Эдийн засгийн сектор	discrete	numeric	Та ямар секторт ажиллаж байна вэ ?
V1348	H113	Тамхи татдаг эсэх	discrete	numeric	Та тамхи татдаг уу?
V1349	H114	Тамхи татаж эхэлсэн нас	contin	numeric	Та хэдэн настайгаасаа эхэлж тамхи татсан бэ?
V1350	H115	Архи уудаг эсэх	discrete	numeric	Та архи уудаг уу?
